

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийн тухай болон Төрийн албаны шинэчлэлийн талаар УИХ-ын дарга Г.Занданшатар нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагын албан хаагч нартай өнөөдөр Соёлын төв өргөөнд 15.00 цагаас уулзах тул байгууллагууд идэвхтэй оролцох.				
1	Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, Төрийн албаны шинэчлэлийн талаар УИХ-ын дарга Г.Занданшатар нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчидтай 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Соёлын төв өргөөнд 15:00 цагийн арга хэмжээнд ЗДТГ, хороодын болон дэргэдэх, хэлтэс албадын 50 албан хаагчийг бүрэн хамрууллаа.			100
<b>Үүрэг даалгавар ХОЁР:</b> Зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод, энгийн, ойлгомжтой хэлбэрээр байршуулж, зөвшөөрөл олгох хурлыг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс олон нийтэд нээлттэй шууд дамжуулах ажлыг зохион байгуулах.				
2	Дүүргийн нутаг дэвсгэрт тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2023 оны 2 дугаар улиралд шинээр авах 7, сунгах 33 нийт 40 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хүсэлт ирүүлсэн. Ажлын хэсгийн 2 удаагийн хурлаар хэлэлцэж, хурлын тэмдэглэлийг үндэслэн Засаг даргын 2023 оны А/41, А/150 дугаар захирамжаар шинээр 4, сунгасан 27 нийт 31 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тамхи худалдах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон. Тамхи худалдах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуйн нэгжийн мэдээлэл болон Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийг дүүргийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасагтай хамтран (chingeltei.gov.mn) цахим хаягт байршуулан ажилласан.			100
<b>Үүрэг даалгавар ГУРАВ:</b> Аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөлтэй хийж буй уулзалтын үеэр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай, бүрэн биелүүлж, хэрэгжилт үр дүнг аж ахуйн нэгж, байгууллагуудад тухай бүр мэдэгдэж, хамтын үйл ажиллагааны үялдаа холбоогоо хангаж ажиллах.				
3	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар хүнс, худалдаа хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөлтэй уулзах уулзалтад 10 аж ахуйн нэгжийг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хамруулан ажиллалаа. Уг уулзалтаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга М.Баяраа, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Х.Эрдэнэбилэг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Д.Цэнд-Аюуш, Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам,			70

	Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын дарга Б.Мөнхбаяр нар хүрэлцэн ирж салбарын бодлого, хамтын үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцсон. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хүрээнд үзлэг шалгалт, стандартын сургалтыг зохион байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			
<b>Үүрэг даалгавар ДӨРӨВ:</b> <i>Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх иргэдийн санал асуулгыг тогтмол авч хэвшүүлэх, түүний мөрөөр үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хэрэгжилт үр дүнг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллах.</i>				
4	Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал авах, түүний мөрөөр үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хүсэлтийг авч, хэрэгжилт ирүүлэх тухай 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 3/1266 өдрийн албан бичгийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасагт хүргүүлэн 7 хоног бүрийн Лхагва гаригийн 14:00 цагаас нэгтгэн Дүүргийн нэгдсэн үйлчилгээний төвд хүргүүлэн ажиллаж байна.			100
<b>Үүрэг даалгавар ТАВ:</b> <i>Нийслэлийн хэмжээнд тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх болон эвдрэл, гэмтэлтэй байгаа автозам болон явган хүний зам талбайг засварлах ажлыг эрчимжүүлж, Үндэсний их баяр наадмаас өмнө бүрэн дуусгах.</i>				
5	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15 байршилд тоглоомын талбайн засвар, тохижилтын ажил хийхээр төлөвлөснөөс 12 байршлын засвар, тохижилтын ажлыг 06 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө дуусгахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэр дэх 75 бичил цэцэрлэгийн арчилгаа, цэвэрлэгээ үйлчилгээг “Чингэлтэй дүүргийн Тохижилт Үйлчилгээ” ХХК хариуцан ажиллаж байна. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газраас 3 байршилд цэвэр усны шугам солих ажил эхэлсэн бөгөөд тус ажил дууссаны дараа явган замын нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.			70
<b>Үүрэг даалгавар ЗУРГАА:</b> <i>Зуслангийн бүсийн төлөвлөлт, хаягжуулалд, орц гарц, хашаа, хайс, нүхэн жорлон зэргийг цэгцлэх ажлаа эрчимжүүлж ажиллах.</i>				
6	Дүүргийн Газар, зохион байгуулалтын албанаас 19, 24 дүгээр хороодын зуслангийн бүсийн хаягжуулалтыг 2023 оны 3 дугаар улиралд багтаан хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Улс туяарах” ХХК 2022-2023 он дамжин хэрэгжиж буй зуслангийн бүсийн 300 өрхийн нүхэн жорлонг бүрэн шинэчлэх ажлын хүрээнд нүхийг ухаж дууссан бүхээг суурилуулах ажил хийж гүйцэтгэж байна. Дүүргийн 24 дүгээр хорооны Засаг даргын ажлын албанаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай гэрээт “Ланд овнер” ХХК-тай хамтран 2022 оны 07-р сард зуслангийн бүсийн орц гарц, хаягжуулалтай холбоотой иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажиллан, 2023 оны 06 дугаар сард хаягжуулалтыг хийхээр төлөвлөсөн. Дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 3-н өрх орц, гарц хааж хашаа барьсныг албан шаардлага хүргүүлэн чөлөөлсөн.			70
<b>Үүрэг даалгавар ДОЛОО:</b> <i>Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” А/309 дүгээр захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ногоон бүсийг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах.</i>				

7	<p>Дүүргийн Цагдаагийн газрын Хоёрдугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтэс, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран өдөр бүр 4 хүний бүрэлдэхүүнтэй явуулын хяналт шалгалтын багыг ногоон бүс болох 19, 20, 22, 23, 24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт эргүүл, хяналт шалгалтаар зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Нийслэлийн Засаг даргын А/309 дүгээр захирамжид тусгагдсан ажил арга хэмжээг хэрэгжүүлэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 1261 иргэн, 906 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт</li> <li>➢ 1245 мэдэгдэл хүргэн</li> <li>➢ 122 сэрэмжлүүлэх мэдээллийг 3260 гаруй иргэнд ухуулга хуудсаар</li> <li>➢ 2500 орчим иргэнд “Хүн бүр байгаль хамгаалагч” гэсэн зурагт хуудсыг</li> <li>➢ 5687 иргэнд цагдаагийн байгууллагын цахим хуудсаар тус тус хүргүүлэн ажиллаа.</li> </ul> <p>Арга хэмжээний хүрээнд ой хээр болон гал түймрийн шинжтэй дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй ба энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтыг эрчимжүүлэн Зуслангийн бүсэд цаг агаарын тогтворгүй нөхцөлд гагнуур хийж байсан 35 иргэнийг үйл ажиллагааг түр зогсоосон.</p> <p>Экологийн цагдаагийн албатай хамтран 4895 иргэнд ухуулга сурталчилгаа, 3397 иргэнд яриа таниулгыг тус тус хүргэн ажиллалаа.</p> <p>Улсын Онцгой комиссын 2023 оны “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Нийслэлийн Онцгой комиссын 2023 оны 03 дугаар албан даалгавар, Чингэлтэй дүүргийн Онцгой комиссын даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/309, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2023 оны А/131 дугаар захирамж, Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн “Шар өвс шатахуунтай адил шатна” аяны хэрэгжилтийг ханган Ой хээрийн гал түймрийн аюултай үед ногоон бүсэд мэргэжлийн анги байгууллага иргэдийн бэлэн байдлыг шалгах, дадлагажуулж, чадавхжуулах хамтын ажиллагаа, үүрэг гүйцэтгэх чадварыг олгох хэрэгжилтийг хангах зорилгоор практик дадлага сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Чингэлтэй дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Зүрх уул”-ын орчимд мэргэжлийн анги, байгууллагатай хамтран зохион байгууллаа.</p> <p>Онцгой байдлын хэлтсээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Улсын Онцгой комиссын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар</li> <li>➢ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар</li> <li>➢ Нийслэлийн Онцгой комиссын 2023 оны 03 дугаар албан даалгавар</li> <li>➢ Дүүргийн Онцгой комиссын даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар</li> <li>➢ Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/309</li> <li>➢ Дүүргийн Засаг даргын 2023 оны А/131 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн “Шар өвс шатахуунтай адил шатна” аяны удирдамжийг хангах ажиллалаа.</li> </ul> <p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах 10 дугаар ангийн бэлтгэл ээлжийн 12, давхардсан тоогоор нийт 360 алба хаагч ногоон бүсийн</p>		<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.</p>	100
---	---	--	---	-----

	<ul style="list-style-type: none"> <li>➤ 23 дугаар хорооны Чингэлтэй хайрхан, Зүрх-уул, Залаатын ам</li> <li>➤ 24 дүгээр хорооны Шадивлан-Яргайт</li> <li>➤ Жигжид /Моби/-Жигжид /Аранзат/</li> <li>➤ Жигжид /Гүнт/-Майхан толгой</li> <li>➤ Санзай-Халзангийн даваа зэрэг 11 газруудаар аялал зугаалга хийж буй нийт 2785 иргэн, 512 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 1800 ширхэг санамж сэрэмжлүүлгийн материалыг тарааж, заавар зөвлөмж өгч ажилласан.</li> </ul> <p>Гал түймрийн Улсын хяналтын байцаагч нар Онцгой мэдээ, MN-25, Монгол HD-TB-д ой хээрийн түймэр, өнжмөл шар өвсний галын аюулгүй байдлын талаар 7 удаа ярилцлага мэдээлэл өгч, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг <a href="http://www.chd.nema.gov.mn">www.chd.nema.gov.mn</a> сайт Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн пейж хуудас, Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> сайт болон дүүргийн 1-24 дүгээр хороодын цахим хуудсаар түгээн, нийт 64 удаа байршуулан иргэд олон нийтэд хүргэн ажилласан.</p>			
<p><b>Үүрэг даалгавар НАИМ:</b> Бүх нийтээр мод тарих өдрөөр хийх ажлын бэлтгэлийг хангуулж, төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг идэвхтэй хамруулж, өмнөх онд тарьж ургуулсан модны ургалтын талаарх үр дүнгийн тухай танилцуулгыг дүүрэг, дүүргээр нь гаргаж танилцуулах.</p>				
8	<p>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд 43.000 мод, бут сөөг тарьснаас 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 70%-н ургалттай байна.</p> <p>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 05 дугаар сарын 13-ны өдөр тус дүүргийн 19 дүгээр хорооны Дээд Салхитад байрлах "Хайрхан хөгжлийн төв", 16 дугаар хорооны Хайлаастайн эцэст "Хоймор хайрхан төв"-д нийт 720 албан хаагч 250 нарс, 5000 бут мод тарьж, 2022 онд тарьсан мод, бут сөөгийг усалж арчлах ажлыг зохион байгуулсан.</p>			100
<p><b>Үүрэг даалгавар ЕС:</b> Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдэд ил задгай архидан согтуурч, танхайрч, иргэдийн ая тухтай байх нөхцөл байдлыг алдагдуулж байгаад анхаарч, хяналт тавьж ажиллах.</p>				
9	<p>Дүүргийн Цагдаагийн газрын хэмжээнд авто эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдэд ил задгай архидан согтуурч, танхайрч, иргэдийн ая тухтай байх нөхцөл байдлыг алдагдуулж байгаад зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр чанга яригч ашиглан яриа таниулга хийж, дуудлага мэдээлэлгүй үед болон өглөө 07:00-08:30 цагийн хооронд автобусны буудал орчимд тогтмол хийх ажлыг хэвшүүлсэн.</p>			70
<p><b>Үүрэг даалгавар АРАВ:</b> Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын хэсгийг үнэн, бодитой мэдээ, мэдээллээр хангаж, ил тод, нээлттэй, ажлын үялдаагаа, хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллах.</p>				
10	<p>Дүүргийн 17, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар "Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл" арга хэмжээг хэрэгжүүлэхээр "Таван од констракшн" ХХК шалгарч, автобусны буудлуудын тохижилтын ажил эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>			70

Биелэлтийн үнэлгээ-85%

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Л.БАЯРМАА

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ